



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 9 сарын 7 өдөр

Дугаар 340

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын 5.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийн дунд хугацааны үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдхүүнийг нэгдүгээр, үнэлгээ хийх ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үнэлгээний дүнг 2015 оны 3 дугаар улиралд удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (Э.Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-д даалгасугай.


САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081205


Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 9 сарын 7 өдрийн
340 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн ахлагч: Э.Оюунсүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Нарийн бичгийн дарга: Д.Баясгалан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын мэргэжилтэн
- Гишүүд:
- Д.Солонго, Сувилахуйн ерөнхий мэргэжилтэн
 - Ц.Тунгалаг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтэн
 - Ц.Болормаа, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн Сувилахуйн албаны дарга
 - Г.Ганхуяг, Монголын сувилагчдын нийгэмлэгийн дэд тэргүүн
 - Г.Бор, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сувилахуйн албаны дарга

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 9 сарын 7 өдрийн
340 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



**“Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийн
дунд хугацааны үнэлгээ хийх ажлын удирдамж**

Улаанбаатар хот

2015.08.27

1. Үндэслэл:

Эрүүл мэндийн сайдын 2012 оны “Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги” батлах тухай” 272 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах.

2. Зорилго:

Сувилахуйн тусламж, үйлчилгээг 2012-2016 онд хөгжүүлэх стратегийн дунд хугацааны үнэлгээг хийж, стратегийн хэрэгжилтийг сайжруулах санал, зөвлөмжөөр хангах.

3. Үйл ажиллагааны чиглэл:

Стратегийн дунд хугацааны үнэлгээгдараах чиглэлээр хийнэ.

- Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт;
- Стратегийн шалгуур үзүүлэлтийн биелэлт;
- Стратегийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гарсан Эрүүл мэндийн сайдын холбогдох тушаалын хэрэгжилт;
- Хамтран ажиллах байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаа;
- Нэмэлт шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авна.

Тухайн стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон бусад холбогдох материалд үндэслэн тоон болон чанарын үзүүлэлтэд үнэлгээ өгнө. Үйл ажиллагааны тайлантай танилцаж, холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад очиж газар дээр нь стратегийн хэрэгжилттэй танилцана.

4. Хамрах хүрээ:

- Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар
- Эрүүл мэндийн яамны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв
- БОЭТ, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Дүүргийн Эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг
- Өрх, сумын Эрүүл мэндийн төв

5. Хугацаа:

2015 оны 09 дүгээр сар

6. Хүрэх үр дүн:

Стратегийн дунд хугацааны үнэлгээний дүн, санал, зөвлөмж гарч, Эрүүл мэнд, спортын яамны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулагдсан байна.